

**“СИЛИКАТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ.**

2021 он 03 сарын 15.

№ 01.

Дархан-Уул аймаг.

“Силикат”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай” асуудлыг авч хэлэлцэн, олонхийн саналыг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Силикат” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 28-ны өдрийн 10 цагт “Силикат” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

- Компанийн санхүүгийн тайлан, Хараат бус аудитын дүгнэлт, тайлан.

-Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.

- Компанийн хэлбэрийг өөрчлөн Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани болгох

- ТУЗ-ийн төсөв.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай мэдэгдэлийг СЗХороо, МХБирж-д мэдэгдэх өдрийг 2021 оны 03 сарын 17-ний өдрөөр тогтоон хурлын мэдэгдэлийг тухайн өдөр МХБиржийн цахим хуудсанд байршуулахыг Б.Энхтуулд даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлд 2 удаагийн давтамжтайгаар хэвлүүлэн хувьцаа эзэмшигчидэд мэдэгдэх өдрийг 2021 оны 03 сарын 19, 04 сарын 03-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хурлын танилцах материалыг 2021 оны 03 сарын 19-ны өдөр хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.


5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжитхурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг 02 дугаар хавсралтаар, ээлжит хурлын мэдэгдэлийг 03 дугаар хавсралтаар эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг 04 дүгээр хавсралтаар тус тус баталсугай. -02 дугаар хавсралтаар баталсан танилцах бичиг баримттай 2021 оны 04 сарын 03-ны өдрөөс 2021 оны 04 сарын 19-ний хооронд “Силикат”ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдрийн буюу 2020 оны 04 сарын 28 -ны өдрийн10 цагаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Н.Цогцлон, Хурал зохион байгуулах комиссын даргаар Д.Уранчимэг гишүүдэд Р.Энхтайван Б.Энхтуул, Тооллогын комиссын даргаар В.Мөнхтамир, гишүүдээр Р.Энхгэрэл Б.Энхтуул нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Н.ЦОГЦЛОН